



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.02.25

№ ТУЗ2019007

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 02 сарын 25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 60.1 дэх заалт, 76 дугаар зүйл, 76.1.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 сарын 10-ний Лхагва гарагийн 16 цагт Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд хуралдуулахаар товлосугай.

ХОЁР. Хурлаар хэлэлцэх асуудал болон хуралдааны дэгийг Тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.

ГУРАВ. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Нямдавааг томилсугай.

ДӨРӨВ. Хурал зохион байгуулах болон тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

- | | |
|-------------------|-------------------------------|
| ➤ Комиссын дарга | Х.Болд |
| ➤ Комиссын гишүүн | Т.Мөнгөнцацрал/ ТУЗНБД |
| ➤ Комиссын гишүүн | Б.Бат-Эрдэнэ/ Ерөнхий менежер |

ТАВ. Хуралд оролцох эрхтэй, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгож, олон нийтэд 2019 оны 02 сарын 27-ны өдөр мэдээлсүгэй.

ЗУРГАА. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өгөх, хавсралт №2-д заагдсан баримт бичигтэй танилцуулах ажлыг Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд 2019 оны 3 сарын 26-ний өдрөөс 2019 оны 3 сарын 29-ний өдрүүдэд 10:00-18:00 цагийн хооронд зохион байгуулахыг комисст даалгасугай.

ДОЛОО. Санал авах хуудасны загварыг тогтоолын хавсралт №3-д зааснаар баталж, Хувьцаа эзэмшигчдийг эчнээ санал өгөх боломжоор хангах ажлыг зохион байгуулахыг ТУЗНБД Т.Мөнгөнцацралд үүрэг болгосугай.

НАЙМ. Эчнээ саналын хуудас хүлээн авах өдрийг 2019 оны 03 сарын 26-ны өдөр эхлүүлж 2019 оны 4 сарын 09-ний өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

ЕС. Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу түгээхийг ТУЗНБД Т.Мөнгөнцацралд даалгасугай.

АРАВ. Хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчид болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллахыг Комисст даалгасугай.

АРВАН НЭГ. Хуралтай холбоотойгоор гарах зардлыг Компаниас гаргахыг Алтайн зам ХК-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА

ТУЗ2019007 тоот тогтоолын хавсралт №1

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТОВ



№	Хэлэлцэх асуудал	Хариуцан танилцуулах, гүйцэтгэх хүн	Шийдвэрийг төсөл	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх Ирцийг танилцуулах	ТУЗНБД Т.Мөнгөнцацрал		16:00-16:30
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон дэгийг танилцуулах	Хурлын дарга М.Нямдаваа		16:30-16:35
3	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ТУЗ-ийн гишүүн Б.Бат-Ирээдүй	ХЭ2019001	16:35-17:35
4	Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай тогтоол	ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэг		
5	ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ТУЗ-ийн дарга М.Нямдаваа	ХЭ2019002	
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	Нэр дэвшүүлэх хорооны дарга С.Баянчулуун	ХЭ2019003	
7	Санал хураалт			17:35-17:50
8	Тооллогын комиссын тогтоол танилцуулах			17:50-18:00
9	Хурлыг хаах			18:00-18:10

ТУЗ2019007 тоот тогтоолын хавсралт №2



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. 2018 оны санхүүгийн тайлан
2. 2018 оны үйл ажиллагааны тайлан
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт
4. 2018 оны ТУЗ-ийн тогтоолууд
5. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
7. ТУЗ-ийн зардлын төсөв
8. Ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн тогтоол
9. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга
10. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоол

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

1. Хувьцаа эзэмшигчийн овог _____
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр _____
3. Хувьцаа эзэмшигчийн нэр _____
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл _____
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар _____
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
7. Санал өгөх хувьцааны тоо _____
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр _____
9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	ХЭ2019001 2018 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай			
2	ХЭ2019002 2018 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай			
3	ХЭ2019003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай			

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ _____ / _____ /

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой.

Саналын хуудас хүчингүйд болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____

Өдөр тутмын хэвлэлд өгөх зарын төсөл



АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Алтайн Зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 10-ны Лхагва гарагийн 16:00 цагт Алтайн зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд зохион байгуулагдана.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, Хүнсчдийн гудамж, Алтан тариа ХК-ийн байрны баруун талд, Алтайн Зам ХК-ийн байр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2019.03.19

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол хуваарилахгүй байх тухай тогтоолын танилцуулга
- ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай

Хурлын материал болон, шийдвэрийн төсөл холбогдох бусад баримттай ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд 99155646 дугаарын утсанд холбогдож авах боломжтой бөгөөд 2019 орны 03 сарын 26-29-ний өдрүүдэд өөрийн байран дээр хурлын материал холрбогдох баримт бичигтэй танилцах бүрэн боломжтой.

Холбоо барих

Зохион байгуулах комиссын дарга: 99110374

ТУЗНБД 99155646

Цахим хуудас: www.altainzam.mn

АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН 2019 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ



Компанийн нэр	Алтайн Зам ХК
Хаяг, утас	Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан баг өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг	2019-04-10-ны 16:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	СХД, 4-р хороо Хүнсчдийн гудамж, Алтан Тарна ХК-ийн баруун талд Алтайн Зам ХК-ийн байр
Хурлын төрөл:	<u>ЭЭЛЖИТ</u> ээлжит бус
Хурал зарлагч	<u>ТУЗ</u> ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2019-02-25
Олон нийтэд зарлах огноо	2019-02-27
Бүртгэх өдөр	2019-03-19
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2019-02-27
Хүргүүлсэн огноо	
Хурлын даргын нэр	М.Нямдаваа
Тооллогын комиссийн дарга, гишүүдийн нэр	Х.Болд /Санхүүгийн албаны дарга/ Б.Бат-Эрдэнэ/ ерөнхий менежер/ Т.Мөнгөнцацрал /ТУЗНБД/
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт, бичгийн хуудсын тоо	 ширхэг хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОММИССЫН ДАРГА

.....

/Х.Болд/



“АЛТАЙН ЗАМ” ХК ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2018.04.10

№ 1-001

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ

Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 4 сарын 10-ны өдрийн ээлжит хуралдааны ирц, Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйл, 63.4 дэх заалт, 67 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хуралдаанд 50056 ширхэг саналын эрхтэй 92 хувийн 1 хувьцаа эзэмшигч итгэмжлэлийн үндсэн дээр оролцож байгаа ба 1 ширхэг хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн, 5 ширхэг хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав нар оролцож байгаа болохыг мэдээлсүгэй.

ХОЁР. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 92 хувийг эзэмшигч нар хуралд оролцож байх тул компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

КОМИССЫН ДАРГА



Х.БОЛД



“АЛТАЙН ЗАМ” ХК ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2019.04.10

№ 1-002

Улаанбаатар хот

САНАЛ ХУРААХ ХУУДСЫГ ТООЛСОН ДҮНГИЙН ТУХАЙ

Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 4 сарын 10-ны өдрийн ээлжит хуралдааны ирц, Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйл, 63.4 дэх заалт, 67 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эчнээ байдлаар урьдчилан өгсөн саналын хуудас байхгүй болохыг дурдсугай.

ХОЁР. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны тооллогоор 50063 ширхэг саналын эрхтэй 3 ширхэг хүчинтэй саналын хуудас тоолсон бөгөөд хүчингүй саналын хуудас тоологдоогүй болохыг мэдэгдсүгэй.

ГУРАВ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хуралдаан болон санал хураалтын ирц, саналын хуудсыг үндэслэн хэлэлцсэн асуудалд өгсөн санал нь дараах дүнд хүрсэн болохыг баталсугай.

№	Хэлэлцсэн асуудал/ шийдвэрийн төсөл	Шийдвэрийн ирц	Татгалзсан	Түдгэлзсэн	Зөвшөөрсөн
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт ХЭ2019001	50063 /92%	0	0	50063
2	ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай/ ХЭ2019002	50063 /92%	0	0	50063
3	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах, шинээр томилох тухай ХЭ2019003	50063 /92%	0	0	50063

ДӨРӨВ. Хүчинтэй саналын хуудсын Уг тогтоолд хавсаргасугай.

КОМИССЫН ДАРГА



Х.БОЛД

**АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо:	2019.04.10	
Эхэлсэн цаг:	16:00	
Дууссан цаг:	17:45	
Хаана:	Улаанбаатар хот. СХД 4-р хороо, “Алтайн Зам” ХК – ийн хурлын танхим	
Хурлын төрөл:	☒ Ээлжит хурал	☐ Ээлжит бус хурал
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	☒ ирсэн	☐ ирээгүй
2	С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
3	Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
4	Г.Сономжамц	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
5	Б.Бат-Ирээдүй	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
6	С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
7	С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
8	Т.Мөнгөнцацрал	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
9	Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
10	С.Пүрэвжав	1 ширхэг хувьцаа эзэмшигч	☒ ирсэн	☐ ирээгүй
11	С.Мягмарсүрэн	5 ширхэг хуваа эзэмшигч	☒ ирсэн	☐ ирээгүй
12	Ньюпрогресс Групп ХХК	50056 ширхэг хуваа эзэмшигч	☒ ирсэн	☐ ирээгүй

ТУЗНБД Т.Мөнгөнцацрал: Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хуралдаанд 50056 ширхэг хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлээр төлөөлөн С.Балжинням оролцохоор бүртгүүлж хүрэлцэн ирсэн байна. Мөн 5 ширхэг хувьцаа эзэмшигч М.Мягмарсүрэн, 1 ширхэг хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав нар хуралдаанд хүрэлцэн ирсэн байна. Өөр хувьцаа эзэмшигч хуралдаанд оролцохоор бүртгүүлээгүй бөгөөд урьдчилан санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно. Ингээд Компанийн тухай хуульд заасан 92 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцон тогтоол гарч байна.

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн С.Баянчулуун	50056 ширхэг	92%
2	С.Мягмарсүрэн	5 ширхэг	
3	С.Пүрэвжав	1 ширхэг	
	Нийт	50063 ширхэг	92%

Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны ирц нь Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1-д заасан нөхцөлийг хангасан байх тул хуралдааныг нээж байна.

Хурлын дарга М.Нямдаваа:

Хуралд хүрэлцэн ирсэн эрхэм ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Энэ удаагийн ээлжит хуралд С.Балжинням Хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцож байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа шууд оръё.

Хурлын дарга М.Нямдаваа: ТУЗ-ийн ТУЗ2019005 тоот Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг дүгнэх тухай, ТУЗ2019006 тоот Ногдол ашигийн тухай тогтоолыг уншин танилцуулав.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Яагаад ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн бэ.

Б.Бат-Ирээдүй: Компани өөрөө их хэмжээний зээлтэй, уг зээл нь уул уурхайн техник тоног төхөөрөмж авахад зарцуулагдсан байгаа. Санхүүгийн тайлан дээр энэ жилийн орлого өндөр байгаа мэт харагдаж байгаа ч нөгөө талдаа хүүгийн өглөг бас бүртгэгдсэн байгаа. Бид өнөөдөр ямар нэг замын төсөлгүйгээр зөвхөн Хөшөөт дээр хөрс хуулалтын ажил гүйцэтгэж байгаа. Тухайн ажил маань өөрөө өндөр үзүүлэлттэй техник тоног төхөөрөмж шаарддаг учраас техник тоног төхөөрөмж худалдан авах шаардлага гарч байгаа. Ингээд өндөр хүүтэй зээл төлж байгаа учраас ногдол ашиг хуваарилаагүй.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Үйл ажиллагааны хувьд

М.Нямдаваа: Бид өнгөрсөн жилүүдэд компанийн үйл ажиллагааг тогтвортой байлгахын тулд ихээхэн хичээсэн. Та бүхэн мэдэж байгаа байх. Өнгөрсөн жилүүдэд замын салбарын нийт ажлыг хятад компаниуд гүйцэтгэх болсон. Үндэсний компаниудад боломж маш хомс болсон. Алтайн Зам ХК-ийн хувьд Мон Эн Ко ХХК-ийн туслан гүйцэтгэгчээр гэрээ байгуулан Хөшөөт дэх уурхай дээр хөрс хуулалтын ажил гүйцэтгэж байна. Энэ ажлыг гүйцэтгэхэд манай замын техник тоног төхөөрөмжүүд бүгд гологдож байгаа. Уул уурхайн тоног төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлт замын тоног төхөөрөмжүүдээс хамаагүй өндөр үзүүлэлттэй. Худалдаад аваад хэрэглэх гэхээр бас элэгдлийн зардал маш өндөр. Бид өөрсдийн хүчин чадалдаа суурилад багхан хэмжээний ажлыг туслан гүйцэтгэгчийн гэрээгээр гүйцэтгэж байна. Гэхдээ энэ бол яг тогтвортой үргэлжлэх гэрээ бас биш. Захиалагч айл маань тайнхаар хийлгэхгүй л гэвэл тэгээд цуцлагдахаар л байгаа. Үйл ажиллагааны хувьд урт хугацааны төлөвлөгөө гаргаад ажиллахад бас хүндхэн байгаа. Гэхдээ аль болох тогтвортой ажиллахыг хичээж байна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: ТУЗ-ийн гишүүдийн тухайд

Н.Энхцэцэг: Гишүүдийн тухайд өмнөх ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох санал оруулж байгаа.

..Хурлын даргын зүгээс асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асууж гишүүд байхгүй гэснээр санал хураалтыг эхлүүлэв.

Хурал зохион байгуулах болон тооллогын комиссын дарга санал хураалтыг эхлүүлж, 16:45 цагт тооллогын комиссын дүнг танилцуулав.

Т.Мөнгөнцацрал өнөөдрийн хуралдаанд эчнээ байдлаар санал өгсөн хувьцаа эзэмшигч байхгүй нийт 50063 ширхэг саналын эрхтэй, 3 хувьцаа эзэмшигч оролцлоо. Тооллогын комиссоос дараах тогтоолыг гаргаж байгаа бөгөөд тогтоолд саналын хуудсыг хавсаргасан болно.

Дараах тогтоолын төсөлд санал хураалт явууллаа.

Нийт 50063 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцон 3 ширхэг хүчинтэй саналын хуудас тоолоо. Хүчингүй болсон саналын хуудас байхгүй

	Хэлэлцсэн асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ХЭ2019001	50063	0	0
2	ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ХЭ2019002	50063	0	0
3	ТУЗ-ийн гишүүдийн эрхийг сунгах	ХЭ2019003	50063	0	0

Шийдвэрлсэн нь .

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

ХЭ2019001, ХЭ2019002, ХЭ2019003, тоот тогтоолын төслийг 100 хувь дэмжин тогтоол гаргаж, энэ тухай холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗНБД-д үүрэг болгов.

Хурлын дарга М.Нямдаваа: Энэ удаагийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал хурааж дууссан тул хуралдааныг хааж байна.

Хуралдаан 2019 оны 04 сарын 10-ны 17:46 цагт өндөрлөв.

ТУЗНБД
ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
Т.МӨНГӨНЦАЦРАЛ
М.НЯМДАВАА





“НЬЮ ПРОГРЕСС ГРУПП” ХХК

Улаанбаатар – 37 ШХ-18080 Сонгино хайрхан
дүүрэг 4-р хороо Толгойтын /18101/ гудамж
Утас/Tel/+976 70172238
Факс/Fax +976 70172251
E-mail: info@newprogressgroup.mn
<http://www.newprogressgroup.mn>

2019-04-19 № 01/29-16

Танай _____-ны № _____

Итгэмжлэл олгох тухай

Манай компани нь Алтайн Зам ХК-ийн 50056 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг ба 2019 оны 04 сарын 10-ны өдөр зохион байгуулагдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд компанийг төлөөлөн 50056 ширхэг хувьцааны эрхээр хуралдаанд оролцож, санал өгөх эрхийг Ерөнхийлөгч С.Балжиннямд энэхүү итгэмжлэлээр олгож байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн овог Сүхрүл
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр Билэгийн
3. Хувьцаа эзэмшигчийн нэр Иннопрогресс гэрлэлт хх.к.
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл 2019.04.10 нх журмын 01/23-16 хэсэг дотроо
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар 5061296
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
7. Санал өгөх хувьцааны тоо — 50056. —
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр _____
9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	ХЭ2019001 2018 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай	50056		
2	ХЭ2019002 2018 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай	50056		
3	ХЭ2019003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	50056		

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____

ТУ32019007 тоот тогтоолын хавсралт №3
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС

1. Хувьцаа эзэмшигчийн овог Сурмаанав
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр Менширсүрэн
3. Хувьцаа эзэмшигчийн нэр Менширсүрэн
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл _____
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар ХТ84091817
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
7. Санал өгөх хувьцааны тоо 5
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр _____
9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэл
1	ХЭ2019001 2018 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай	5		
2	ХЭ2019002 2018 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай	5		
3	ХЭ2019003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	5		


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ С. Менширсүрэн / С. Менширсүрэн
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС



1. Хувьцаа эзэмшигчийн овог Чойнзиг
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр Сүрэнжав
3. Хувьцаа эзэмшигчийн нэр Дурэвжав
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл _____
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар 1084121391
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар 57-48
7. Санал өгөх хувьцааны тоо 1
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр Арз капитал
9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэл
1	ХЭ2019001 2018 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай	1		
2	ХЭ2019002 2018 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай	1		
3	ХЭ2019003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	1		

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ Сүрэнжав
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.04.10

№ ХЭ2019001

Улаанбаатар хот

2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ БАТЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн 2019 оны 4 сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Компанийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлттэй танилцан Леон Аудит ХХК-ийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, ТУЗ-ийн танилцуулсан дүгнэлтийг баталсугай.

ХОЁР. 201% онд үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахыг ТУЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.04.10

№ ХЭ2019003

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг сунгах, шинээр томилох тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 4 сарын 10-ны өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэл, Тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл 77.1; 62 дугаар зүйл, 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 7.7.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналыг авсан нэр бүхий 9 гишүүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурал хуралдах хүртэл хугацаагаар сунгасугай.

ТУЗ-ийн ердийн гишүүн

Сандагийн Балжинням

Сандагийн Баянчулуун

Сандагийн Баянмөнх

Маамуугийн Нямдаваа

Цэндсүрэнгийн Ганцэцэг

Норовын Энхцэцэг

Хараат бус гишүүн

Ганболдын Сономжамц

Баярдалайн Бат-Ирээдүй

Тунгалагийн Мөнгөнцарал

ХОЁР. ТУЗ-ийн гишүүнээр улиран сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, Компанийн засаглалын зарчмыг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АЛТАЙН ЗАМ” ХК -ИЙН ЗАХИРАЛ ТАНАА

Бид 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, мөн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол гол бодлогууд ба бусад нэмэлт тайлбар мэдээллүүдийг багтаасан “АЛТАЙН ЗАМ” ХК ийн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлага

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан эсвэл алдааны улмаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлага мөн багтдаг.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол эдгээр санхүүгийн тайлангуудад аудитын дүгнэлт өгөх явдал юм. Бид өөрсдийн аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаанаас ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлтүүд ба тодруулгуудын талаар аудитын нотолгоог олж авахын тулд аудитын горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгосон горимууд нь аудитор залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг төлөвлөхийн тулд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

Түүнчлэн аудитын ажилд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудын үндэслэлтэй байдал болон санхүүгийн тайлангийн толилуулгыг ерөнхийд нь үнэлж үзэх ажлууд багтдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоонууд нь аудитын дүгнэлт өгөхөд хангалттай ба зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэж байна.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангууд 2018 оны 12 дугаар сарын 31-ээрх “АЛТАЙН ЗАМ” ХК - ийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

ЗАХИРАЛ

Г.ДЭЛГЭРЦЭЦЭГ

2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН 25

МОНГОЛ УЛС

УЛААНБААТАР ХОТ



"АЛТАЙН ЗАМ" ХК
 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
 ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

	Тэмдэглэл	2018.12.31	2017.12.31
Хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	14,594,363	2,952,675,060
Дансны авлага		1,820,026,685	3,513,947,792
Татвар, НДШ-ийн авлага	5		6,963,701
Бусад авлага	6	4,059,802,658	1,625,958,627
Бараа материал	7	3,236,411,582	4,447,872,270
Урьдчилж төлсөн зардал тооцоо	8	564,115,907	742,657,924
Эргэлтийн хөрөнгийн дүн		9,694,951,196	13,290,075,373
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	9	13,984,060,099	9,790,736,398
Биет бус хөрөнгө	10	9,678,599	9,929,284
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		13,993,738,699	9,800,665,682
Нийт хөрөнгийн дүн		23,688,689,894	23,090,741,055
Өр ба эзний өмч			
Богино хугацаатай өр			
Дансны өглөг		2,189,165,895	2,776,175,522
Цалингийн өглөг		1,858,786	4,049,258
Татварын өр	11	202,338,195	177,533,786
НДШ-ийн өглөг		46,194,509	69,009,345
Банкны богино хугацаат зээл		4,706,951,804	1,055,000,000
Хүүний өглөг		364,637,395	3,457,373
Урьдчилж орсон орлого		845,829,542	1,590,681,757
Нөөц /өр төлбөр/		29,425,761	632,703,047
Бусад богино хугацаат өр төлбөр		2,148,018,584	4,866,931,501
Богино хугацаат өр төлбөрийн дүн		10,534,420,473	11,175,541,590
Урт хугацаат өр			
Урт хугацаат зээл		3,244,491,625	2,656,846,625
Урт хугацаат өр төлбөрийн дүн		3,244,491,625	2,656,846,625
Нийт өр төлбөрийн дүн		13,778,912,098	13,832,388,215
Эздийн өмч			
Хувийн өмч	1	5,415,300	5,415,300
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		631,113,120	631,113,120
Хуримтлагдсан ашиг		9,273,249,377	8,621,824,420
Эздийн өмчийн дүн		9,909,777,797	9,258,352,840
Нийт өр ба эзний өмчийн дүн		23,688,689,894	23,090,741,055

"АЛТАЙН ЗАМ" ХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

	Тэмдэглэл	2018.12.31	2017.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)		22,776,634,901	13,886,312,835
Борлуулалтын өртөг		19,523,411,319	10,239,125,839
Нийт ашиг (алдагдал)		3,253,223,582	3,647,186,995
Хүүний орлого		29,248,635	5,516,840
Бусад орлого		135,904,545	343,106,414
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(2,894,461,231)	(3,661,552,237)
Бусад зардал		(268,220,006)	(330,000)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, (гарз)		63,447,917	(38,154,702)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, (гарз)		(13,288,920)	(5,420,230)
Татвар төлөхийн өмнөх ашиг		305,854,523	290,353,080
Татварын зардал		8,151,853	3,400,046
Татвар төлсөний дараах ашиг		297,702,670	286,953,033

"АЛТАЙН ЗАМ" ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР

ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Бүгд
2017 оны 12 сарын 31 ны өдөр	5,415,300	631,113,120	8,621,824,420	9,258,352,840
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			353,722,286	353,722,286
Тайлан үеийн цэвэр ашиг алдагдал			297,702,670	297,702,670
2018 оны 12 сарын 31 ны өдөр	5,415,300	631,113,120	9,273,249,377	9,909,777,797

"АЛТАЙН ЗАМ" ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

2018.12.31

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Цэвэр ашиг	297,702,670
Тохируулга	3,781,081,735
Элэгдлийн зардал	1,777,984,567
Авлага бараа материал урьдчилаж төлсөн тооцоо нэмэгдэх	3,090,887,511
Авлага бараа материал урьдчилаж төлсөн тооцоо хасагдах	
Богино хугацаат өглөгийн нэмэгдэх өөрчлөлт	
Богино хугацаат өглөгийн хасагдах өөрчлөлт	(4,293,072,921)

Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн

4,654,583,563

Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ

Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,400,946,500
Хүлээн авсан хүүний орлого	29,248,635
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгаа	(16,350,811,694)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн

(11,920,616,559)

Санхүүгийн үйл ажиллагаа

Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	27,107,605,026
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(22,823,811,697)
Валютин ханшийн тэгшитгэлийн ашиг	44,158,970

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн

4,327,952,299

Мөнгөн хөрөнгийн өсөлт бууралт

(2,938,080,697)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл

2,952,675,060

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл

14,594,363

"АЛТАЙН ЗАМ" ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
 2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
 ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2018.12.31	2017.12.31
Касс	725,571	195,249
Харилцах	13,868,792	2,952,479,811
Дүн	14,594,363	2,952,675,060

5. Татвар, НДШ-ийн авлага

	2018.12.31	2017.12.31
ААНОАТ-ын авлага		6,963,701
НӨАТ-ын авлага		
НДШ-ийн авлага		
ХХОАТ-ын авлага		
Дүн		6,963,701

6. Бусад авлага

	2018.12.31	2017.12.31
Холбоотой талаас авах авлага	3,281,950,808	1,554,886,190
Ажилчдаас авах авлага	777,851,850	71,072,437
Дүн	4,059,802,658	1,625,958,627

7. Бараа материал

	2018.12.31	2017.12.31
Түүхий эд материал	448,652,131	465,372,357
Туусаагүй үйлдвэрлэл	269,942,043	2,090,560,681
Бараа /сэлбэг/	1,075,204,329	696,829,951
Хангамжийн материал /багаж/	203,266,292	144,255,820
Бусад	1,239,346,786	1,050,853,460
Дүн	3,236,411,582	4,447,872,270

"АЛТАЙН ЗАМ" ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
 2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
 ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

8. Урьдчилж төлсөн зардал тооцоо

	2018.12.31	2017.12.31
Урьдчилж төлсөн зардал	122,563,325	384,642,407
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр	441,552,582	358,015,517
Дүн	564,115,907	742,657,924

11. Татварын өр

	2018.12.31	2017.12.31
ААНОАТ-ын өр		
НӨАТ-ын өр	4,826,625	176,280,391
ХХОАТ-ын өр	182,021,641	1,253,395
ОАТ-ын өр	15,489,930	
Бусад татварын өр		
Дүн	202,338,195	177,533,786

12. Ерөнхий ба удирдлагын зардал

	2018.12.31	2017.12.31
Ажиллагчдын цалингийн зардал	205,456,643	163,485,075
Аж ахуй нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	25,093,042	21,821,763
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	11,470,000	16,561,800
Томилолтын зардал	24,922,625	22,821,839
Бичиг хэргийн зардал	14,232,209	82,261,905
Шуудан холбооны зардал	4,411,589	3,800,464
Мэргэжлийн үйлчилгээний зардал	753,864,342	749,034,250
Сургалтын зардал	41,567,359	150,000
Даатгалын зардал	212,355	363,955
Ашиглалтын зардал	805,000	553,785,473
Засварын зардал	1,220,912,761	34,314,524
Элэгдэл, хорогдлын зардал	57,148,913	1,796,940,713
Түрээсийн зардал	3,959,653	53,043,071
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	61,000	2,773,871
Тээврийн зардал	32,471,297	177,000
Шатахууны зардал	2,148,052	74,795,945
Зар сурталчилгааны зардал	495,724,391	6,026,364
Зээлийн хүүгийн зардал		79,394,226
Дүн	2,894,461,231	3,661,552,237

"АЛТАЙН ЗАМ" ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
 2018 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
 ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

9. Үндсэн хөрөнгө

Өртөг	Барилга байгууламж	Тоног техөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Бусад	Бүгд
2017 оны 12 дугаар сарын 31	481,694,241	2,593,377,470	17,952,675,836	65,066,353	77,173,790	151,556,519	21,321,544,207
Тайлангийн хугацаанд нэмэгдсэн	831,692,032		5,810,012,347		8,267,600		6,649,971,978
Тайлангийн хугацаанд хасагдсан		154,123,840	335,559,505	1,000,000			
2018 оны 12 дугаар сарын 31	1,313,386,272	2,439,253,629	23,427,128,677	64,066,353	85,441,390	151,556,519	27,480,832,840
Хуримтлагдсан элэгдэл							
2017 оны 12 дугаар сарын 31	156,464,408	1,937,691,352	9,171,860,690	51,510,217	66,314,441	146,966,701	11,530,807,810
Тайлант хугацааны элэгдэл	33,993,076	232,835,157	2,111,349,973	3,501,018	6,529,197	3,150,632	2,391,359,053
Тайлангийн хугацаанд хасагдсан		153,328,211	271,065,911	1,000,000			
2018 оны 12 дугаар сарын 31	190,457,484	2,017,198,297	11,012,144,753	54,011,235	72,843,638	150,117,333	13,496,772,741
2017 оны 12 сарын 31 дансны цэвэр дүн	325,229,832	655,686,118	8,780,815,145	13,556,136	10,859,349	4,589,818	9,790,736,398
2018 оны 12 сарын 31 дансны цэвэр дүн	1,122,928,788	422,055,332	12,414,983,924	10,055,118	12,597,751	1,439,186	13,984,060,099



“АЛТАЙН ЗАМ” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.02.04

№ ТУЗ2019005

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ
ДҮГНЭХ ТУХАЙ**

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 02 сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.11 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагын танилцуулсан тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХОЁР. Алтай зам ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ГУРАВ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуунд даалгасугай.

ДӨРӨВ. Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөсөн болон тогтоосон цаг хугацаанд үнэн зөвөөр тайлагнан, журмын дагуу НББ-д тусган ажиллахыг Алтайн зам ХК /Б.Энхбат, Э.Өлзийхутаг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.02.04

№ ТУЗ2019006

Улаанбаатар хот

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 сарын 04-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2019 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

ХОЁР. Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, тайлагнахыг ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.04.10

№ ТУЗ2019023

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ДЭД ХОРООДЫГ БАЙГУУЛАН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 4 сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйл, 78.1 дэх заалт, 79 дүгээр зүйл, 81 дүгээр зүйл 81.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ХЭ2016003 тоот тогтоолыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн ТУЗ нь дэргэдээ дараахи хороодтой байхаар тогтоосугай..

- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо

ХОЁР. Дэд хороодын дарга болон гишүүдийнг дараахи бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Аудитын хорооны дарга	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Мөнгөнцацрал
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх
- Нэр дэвшүүлэх хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуун
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Балжинням
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Сономжамц
- Цалин, урамшууллын хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн Ц.Ганцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй

ГУРАВ: Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар гишүүдийн дийлэнх олонхын саналыг авсан М.Нямдавааг улируулан сонгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА